

ДОРНОГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн ИТХ-ын захиалга, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

“Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр ашиг”



Удирдлага, зохион байгуулалт, хяналт, хариуцлагын тогтолцоогүйгээс сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

2017 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Дорноговь аймгийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа Аудитын менежер Ч.Хэрлэнчимэг Ахлах аудитор Ц.Лүндэгмаа Шинжээч П.Энхбаяр 2017 оны 7 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-2734, 7052-3020 дугаарын утас, 7052-2734 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: Орон нутгийн өмчийн 3-р байр	<i>Товчилсон үгийн тайлбар</i>3 <i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</i>.....4 <i>Ерөнхий мэдээлэл</i>.....5-6 БҮЛЭГ 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй, дурсгалт газрыг хамгаалах ажил хийгдээгүй байна. 1.1. Үйл ажиллагаа нь нэгдсэн удирдлага, зохион байгуулалтгүй явагдсанаас хуулиар заасан ТХГН-ийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.....7-8 1.2. Сангийн үйл ажиллагаатай холбогдон гарсан журмууд нь орлогын эх үүсвэр бүрдүүлэхэд чиглэгдсэн бөгөөд үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, төлөвлөлт, хяналт, хариуцлагын тогтолцоо алдагдсан байна.....8-9 БҮЛЭГ 2. Орлогын эх үүсвэр, зардлыг төлөвлөөгүйгээс сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. 2.1. ТХГН-ийг хамгаалах ажлын төсөв, санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр болон үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлыг хуулийн дагуу төлөвлөж батлуулаагүй байна.....10 2.2. ТХГН-т үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн хөлсийг батлагдсан үнэ тарифын дагуу хураасан боловч хураамжийн үнэ тариф өөрчлөгдсөн тухай бүрт тасалбарын үлдэгдлийн тооцоо хийгээгүй байна.....10-11 2.3. Тасалбарын орлого, зарлагын 2013-2015 оны эд хариуцагчийн тайлан байхгүйгээс хураамжийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.....11-12 2.4. Нягтлан бодогч, эд хариуцагч удаа дараа солигдон ажилласан, удирдлага зохион байгуулалт, хяналт орхигдсоноос хууль, журам зөрчиж сангийн хөрөнгийг зориулалт бусаар, үрэлгэн зарцуулсан байна.....12-15 2.5. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ажлуудад ХАА-г зохион байгуулаагүй, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлаагүй байна.....15-18 БҮЛЭГ 3. Холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүйгээс орон нутгийн ТХГНС-ийн үйл ажиллагаанд тавих хяналт орхигдсон байна. 3.1. Мөнгөн кассын журмыг мөрдөж ажиллаагүй байна.....19-20 3.2. Сангийн хөрөнгийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад тавих шат шатны хяналт орхигдсон байна.....20 3.3. Орон нутгийн тусгай хамгаалалтын горим тогтоож, хяналт тавьж ажиллаагүй байна.....20-21 Дүгнэлт.....22 Зөвлөмж.....23 Холбогдох байгууллагын санал.....24-27 Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар.....28
--	---

Товчилсон үгийн тайлбар

[illegible]



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 1/13

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, 19 дүгээр зүйлийн 19.3.3, Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаалын 5 дах заалт, 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн ИТХ-ын захиалга, Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн "Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн үйл ажиллагааны үр дүн, үр ашиг" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Ч.Хэрлэнчимэгт үүрэг болгосугай.

3. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Засаг даргад, Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргад, "Тохижилт-Сайншанд" хот тохижилтын газарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аймгийн ИТХ-ын захиалга, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгин сангийн үйл ажиллагаа, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийв.

Аудитын зорилт:

“Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн үйл ажиллагаа, үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийнэ.

- Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн үйл ажиллагаа үр нөлөөтэй зохион байгуулагдсан эсэх
- Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн орлогыг хууль журамд заасны дагуу бүрдүүлж зарцуулсан эсэх
- Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх

Хамарсан хүрээ:

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн 2013-2016 он болон 2017 оны 1-р улирлын үйл ажиллагаанд аудит хийж Сайншанд сумын ЗДТГ, “Хамарын хийдийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ, “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газар зэрэг байгууллагуудыг хамрууллаа.

Аргазүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын аргазүйг ашиглан холбогдох байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд, санхүүгийн албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, судлах, дүн шинжилгээ болон харьцуулалт хийх, тулган баталгаажуулах зэрэг аргазүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж өглөө.

Хязгаарлалт: Аудитад хамрагдсан хугацааны баримтуудаас ИТХ-ын зарим тогтоол олдоогүй, урамшуулал тооцох тухай шийдвэр байхгүй, эд хариуцагч тасалбарын тайлан тооцоог 2013-2015 онуудад гаргаагүй, ОНТХГНСанг хариуцсан эд хариуцагч 4 удаа, нягтлан бодогч 5 удаа солигдсон зэрэг нь аудитын хугацаа, аудитын нотлох баримт цуглуулах, тулган баталгаажуулалт хийх зэрэгт хүндрэл учруулж байлаа.

Ерөнхий мэдээлэл.

Аймгийн ИТХ-ын 1998 оны 6/8 тоот тогтоолоор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2, 28 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Говийн Ү ноён хутагт Дулдуйтын Равжаагийн амьдрал уран бүтээлтэй холбоотой Өргөн, Эрдэнэ, Сайншанд сумдын уулзвар нутаг дахь Хамарын хийд, түүний орчим дахь 108 агуй, Тонтой овоо, Мэргэн вангийн сүлд тахилгын суурин, Саран хөхөөний намтар театрын буурь, Шамбалын ерөөл тавьсан хаалга зэргийг багтаасан 2279 га талбай бүхий газар нутгийг аймгийн тусгай хамгаалалтад авч, аймгийн дурсгалт газрын түүх соёлын дурсгалт газрын төрөлд хамааруулан хилийн цэс, талбайн хэмжээг баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2010 оны 5/04 тоот тогтоолоор дурсгалт газрын хэмжээг 44627 га талбай, 2014 оны 5/03 тоот тогтоолоор Хамрын хийд орчмын талбайн хэмжээг нэмэгдүүлж 45200.83 га болгож хилийн цэс, талбайн хэмжээг баталсан байна.

Цогцолборт газрыг бүрдүүлж байгаа хэсгүүд нь өөр хоорондоо ялгаатай, онцлог тогтоцтой газар байдаг байна. Жишээ нь: Ханбаян Зүрх уул далайн түвшнээс дээш 1031 м өргөгдсөн эц, шовх, хар чулуун уул байхад Зоогийн хоолой нь нам уулсын дундуур гарсан тэгш хөндий юм. Шамбал уул, Хамарын хийд орчим нь тэгш талдуу, агуй хонгил ихтэй, галт уулын дэлбэрэлтээс үүсэн тогтсон сул асгарсан улаан чулуу, хадтай байхад Хашаатын говь нь говь цөлийн шинжийг бүрэн харуулсан элсэрхэг бор саарал хөрстэй нам дор газар ба говийн экосистемийг төлөөлөх заг, хайлаасан ой ургадаг байна.

Ургамлын хувьд говийн цөлөрхөг хээр, цөлийн үндсэн төлөөлөл болох ургамал, нэн ховор ургамлын зүйлийн бүрдэлтэй. Сайншанд сумын хэмжээнд ургамлын аймгийн зүйлийн нарийвчилсан судалгаа хийгдээгүй байна.

Цогцолборт газар нь олон төрөл зүйлийн амьтадтай. 34 зүйл хөхтөн амьдардаг. Улаан номонд орсон нэн ховор амьтан дэлхийд эврээрээ тэргүүлдэг аргаль хонь, янгир ямаа, хулан адуу, хар сүүлтий, эрээн хүрнэ, мөн Зэрлэг амьтан ургамлын аймгийн ховордсон зүйлийн олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн 2 дугаар хавсралтад орсон мануул мий, саарал чоноболон идлэг шонхор, хулан жороо зэрэг шувууд, үнэг, хярс, цагаан зээр, хонин гүрвэл зэрэг говь цөлийн амьтдаар баялаг байдаг байна.

Цогцолбор газарт 33 зүйл шувуу нутаглаж, нүүдэллэн ирж зусдаг байна. Монгол орны хэмжээнд нэн ховордсон хулан жороо, ногтруу шувууд энэ нутагт нутагладаг байна.

Монгол оронд 13 зүйл гүрвэл, Дорноговь аймагт 7 зүйл гүрвэл, 4 зүйл могой, байдгаас Ханбаян Зүрх уул, зоогийн хоолой, Хашаатын говиор говийн гүрвэл, могой гүрвэл, нарийн могой зэрэг 6 зүйл мөлхөгч амьдардаг. Энэ нутгаар ховор, ховордож буй төрөл зүйл их байх магадлалтай бөгөөд нарийвчилсан судалгаа хийгдээгүй байна.

Дорноговь аймгийн Сайншанд сум нь чулуун зэвсэг, хадны сүг зураг, хүрлийн болон төмрийн үеийн зэр зэвсэг, булш бунхан, гэрэлт хөшөө, хот балгадын туурь зэрэг түүх соёлын үнэт дурсгалууд, 80 гаруй сая жилийн тэртээ амьдарч байсан үлэг

гүрвэлийн чулуужсан яс, 200-аад сая жилийн тэртээх далай, тэнгисийн амьтан, ургамлын үлдэгдэл, чулуужсан мод, 30 сая жилийн өмнө амьдарч байсан намгийн хирон, одос үхэр, тэмээн хяруулын ул мөр зэрэг палентологийн чухал олдворууд бүхий унаган төрхөөрөө байгаа говь нутаг юм.

Байгалийн баялгийн хувьд жонш, цеолит, хүрэн нүүрс, уран, нефтийн ордуудтай барилгын материалд ашигладаг элс, шавар, өнгө бүрийн шороон будгийн нөөцтэй. Цогцолбор газар нутагт алт, мөнгө, оюу зэрэг эрдэнэсээр баялаг, эрдэнийн өнгөт чулуу, усан болон утаат мана, чүнчигноров, утаат болор зэрэг эрдэнийн чулуу ихтэй байдаг талаар зарим судалгааны материалд дурдсан хэдий ч одоогийн байдлаар нарийвчилсан судалгаа хийгдээгүй байна.

Цогцолборт газрын онцлог зүйл нь Говийн их ноён хутагт Данзанравжаагийн амьдарч байсан нутаг бөгөөд түүний үүсгэн ба йгуулсан Хамарын хийд, амьдрал уран бүтээлтэй холбогдолтой шашин, түүх, бичиг, соёлын өв, дурсгалт зүйлс, хосгүй үзмэрүүд, эдгээрийг хадгалж үлдсэн Шамбалын уул, төрийн хэргэмт Говийн тахилгат Ханбаянзүрх хайрхан уул болон чулуун зэвсэг, хадны сүг зураг, хот балгадын туурь, түүх соёлын үнэт дурсгалуудтай газар нутаг юм.

Байгаль, түүхийн онцлог, дэд бүтцийн хөгжил нь аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж байгаагаас цогцолбор газарт аялагчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдсэн.

Тулгарч буй бэрхшээл, шалтгаан. 1. *Амьтан, ургамлын аймагт:* Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, бэлчээрийн доройтол, усны нөөц багассан, уул уурхайн ашиглалт, шар оготны тоо толгой, салаа зам, малын тоо ихэссэн, хур тунадас багассан, хүний буруутай үйл ажиллагаа, хамгаалалт муу, 2. *Цогцолбор газрыг хамгаалахад:* Хамарын хийдийн орчинд суурьшил ихэссэн, хур хог бий болж хөрс, орчны бохирдол ихэссэн, нинжа нар цогцолборт газрыг ухаж малтан газар хөрс ихээр сүйтгэдэг, мэдээлэл, сурталчилгааны мэргэжилтэнгүй, цогцолборт газрын хамгаалалтын тусгай горим байхгүй, 3. *Аялал, жуулчлалын үйл ажиллагаанд:* гэр буудлууд зохион байгуулалтгүй, чанаргүй үйлчилгээ явуулдаг, авто машины тоо олширсон, аялагчид замбараагүй буудаллах, гал түлэх, хог хаях зөрчил ихэссэн, аялал жуулчлалыг зохистой явуулах тусгай журам байхгүй байна.

Бүлэг 1

**Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль
тогтоомжийг хэрэгжүүлээгүй, дурсгалт газрыг хамгаалах
ажил хийгдээгүй байна.**

1.1. Үйл ажиллагаа нь нэгдсэн удирдлага, зохион байгуулалтгүй явагдсанаас хуулиар заасан ТХГН-ийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

1.1.1. ТХГН-ийн орчны бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлд орчны бүсийн зөвлөлтэй /Орчны бүсийн зөвлөлд сумын ИТХТ-ээс 2-оос доошгүй, нутгийн иргэдээс 3-аас доошгүй төлөөлөгч, хамгаалалтын захиргаанаас 2 төлөөлөгч/ байхаар заасан байна. Орчны бүсийн зөвлөл нь ТХГН, түүний орчны бүсэд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд Засаг даргад туслах, зөвлөх, санал тавих, орчны бүсийн санд хөрөнгө төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, ТХГН, түүний орчны бүсийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, мэдээллийг олон нийтэд түгээх эрх үүрэгтэй боловч Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн зөвлөлийг 2013-2015 онуудад байгуулаагүй байна.

1.1.2. ТХГН-ийн орчны бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлд Засаг дарга хамгаалалтын захиргаа, зөвлөлтэй хамтран орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ гэж заасан байна. Аймгийн Засаг даргын 2015 оны А/28 тоот захирамжаар Хамрын хийд орчмын цогцолборт газрын менежментийн хяналт шинжилгээний зөвлөлийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан хэдий ч үйл ажиллагаа явуулаагүй байна.

1.1.3. Хамрын хийд орчмын цогцолборт газрыг хариуцсан хамгаалалтын захиргааг 2015 онд байгуулах шийдвэр гарсан бөгөөд үйл ажиллагаа явагдаагүй байна.

1.1.4. Сайншанд сумын Засаг даргын 2016 оны А/138 тоот захирамжаар орон нутгийн тусгай санг татан буулгах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсэг байгуулснаар Цогцолбор газрын үйл ажиллагааг бие даан хэрэгжүүлэх “ТХГН-ын хамгаалалтын захиргаа” ААТҮГ-ыг байгуулсан байна. Тус байгууллага 2016 оны 7 дугаар сараас 12 дугаар сар хүртэл үйл ажиллагаа явуулжээ.

1.1.4. Сумын ИТХ-ын 2016 оны 35 дугаар тогтоолоор “Хамарын хийдийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ-ын дүрэм, ТУЗ-ийг байгуулсан ба ТУЗ-ийн 2016 оны 01 тоот тогтоолоор ОНӨААТҮГ-ын бүтцийг 12 орон тоогоор, төсвийн зарлагын төлөвлөгөөг 2016 оны сүүлийн хагас жилээр 92.2 сая төгрөгөөр баталсан байна. Зардлын төсөвт сургалт, сурталчилгааны зардал, хамгаалалтын үйл ажиллагааны зардал, хөрөнгө, тоног төхөөрөмж авах, тасалбар захиалах зардлыг тусгасан байна. Гүйцэтгэлээр 72.2 сая төгрөгийн зардал гарсны дотор 27.0 сая төгрөгийн цалин, НДШ, татварын зардал, 18.3 сая төгрөгийн хөрөнгийн зардал гаргаж Сайншанд сумын орлогод 20.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

1.1.5. “Хамарын хийдийн ТХЦГ-ын хамгаалалтын захиргаа” ААТҮГ-ыг 2016 оны 12 дугаар сард татан буулгаж “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газарт ТХГН-ийн хамгаалалтын захиргааны ажиллагаа болон үйл ажиллагааг шилжүүлж нийлүүлсэн байна. ОНТХГН-ийн хамгаалалтын захиргаа нь хот тохижилтын газартай нэгдсэнээр хог цэвэрлэгээ, тохижилтын ажил хийж ТХГН-ийг хамгаалах үндсэн ажил, үүргээ гүйцэтгээгүй байна.

1.1.6. Сайншанд сумын ИТХ-ын 2016 оны 02/12 тоот тогтоолоор ТХГН-т зорчих иргэдээс авах хураамж, тээврийн хэрэгслээс авах хураамжийн тасалбарын 2017 онд орлогын төсвийг 400.0 сая төгрөгөөр баталсан бөгөөд Сайншанд сумын төсвийн орлогын дансанд төвлөрүүлж байна.

1.1.7. “Тохижилт Сайншанд” хот тохижилтын газрын ТХГН-ийн хамгаалалтын захиргаанд 11 хүн ажилладаг бөгөөд улсын байцаагчийн эрхтэй хүн байхгүй байна. ХХЦГ-ыг хариуцсан мэргэжилтэн 1, нягтлан бодогч 1, эд хариуцагч 1, байгаль орчны мэргэжилтэн 1, жолооч 1, тасалбар түгээгч 6 нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг байна. Хамгаалалтын захиргааны төсвийг 2017 онд 82.7 сая төгрөгөөр баталсны 42.8 хувь буюу 35.4 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал, 36.3 хувь буюу 30.0 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд /тасалбар хэвлүүлэх зардал/ төсөвлөжээ. 2017 оны 6 сард төсвийн тодотголоор цалингийн зардлыг 31.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Энэхүү төсөвт ТХГН-ийг хамгаалах, сурталчлах, судалгаа хийх зардал ороогүй байна.

1.1.8. Өмнөх жилүүдэд Сайншанд сумын ЗДТГ-ын БОАЖ хариуцсан мэргэжилтэн цогцолбор газрын байгаль хамгаалах асуудлыг хариуцан ажилладаг, Ханбаянзүрх уул, Хашаатын говь орчмыг идэвхтэн байгаль хамгаалагч 2 хүн хариуцан хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг, Хамарын хийд орчмын байгаль орчныг хамгаалалт хариуцсан ажилтан хариуцан ажилладаг байсан байна.

1.1.9. Хамгаалалт хариуцсан ажилтан болон байгаль хамгаалагч нь байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэгтэй, үүргээ гүйцэтгэх үедээ ялгах тэмдэг, хувцас, зэвсэг хэрэгсэлтэй байх байтал Сайншанд сумын БОАЖ хариуцсан мэргэжилтэн Хамрын хийдэд байнга ажилладаггүй, хамгаалалт хариуцсан ажилтан нь дүрэмт хувцас, үнэмлэх, тэмдэггүй учир иргэдэд шаардлага тавьж хууль тогтоомж зөрчсөн иргэдийн бичиг баримтыг шалгах, ТХГН-ийн горим, журмыг тайлбарлан таниулах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг байна.

1.1.10. Аймаг, сумын удирдлага 2014-2015 онуудад ОНТХГН-ийн талаарх төрийн бодлого, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулах, хамгаалалтыг эрхлэх эрхээ хэрэгжүүлээгүй, ОНТХГН-ийн үйл ажиллагаа нь нэгдсэн удирдлага, зохион байгуулалтгүй явж ирсэн, одоогийн бүтэц зохион байгуулалт оновчгүй, орлого, зардал, хөрөнгө, хяналтын орчинг нэг дор бүрдүүлээгүй зэргээс ТХГН-ийг хамгаалах хуулиар заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх менежмент дутагдаж байна.

1.2. Сангийн үйл ажиллагаатай холбогдон гарсан журмууд нь орлогын эх үүсвэр бүрдүүлэхэд чиглэгдсэн бөгөөд үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, төлөвлөлт, хяналт, хариуцлагын тогтолцоо алдагдсан байна.

1.2.1. 2007 оны 05, 2013 оны 04, 2014 оны 08/04, тогтоолуудаар ТНТХГН-т дагаж мөрдөх журам, "ОНТХГН-т зорчих иргэдэд олгох эрхийн төлбөр"-ийн хэмжээг, 2013 оны 04/08, 2015 оны 11/03 тоот тогтоолуудаар Сайншанд суманд зорчих иргэдээс

төлбөр авах журам, Хамарын хийдийн цогцолбор газар нутагт зорчих иргэн, тээврийн хэрэгслээс авах хураамжийн журам, төлбөрийн хэмжээг тогтоож, сангийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж ирсэн байна.

1.2.2. ТХГ-ын орчны бүсийг хөгжүүлэх, нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих зорилго бүхий орчны бүсийн санг байгуулж болно, Төсвийн тухай хуулиар орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг энэ хуулиар зохицуулна гэж заасан. Эдгээр заалтын дагуу 2014 онд ОНТХГНСан дансаар ОНТХГНС-ийн орлого, зарлагын гүйлгээг хийж байсан ба 2015-2016 оны эхний хагас жилд тус дансыг хааж Байгаль хамгаалах сангийн дансанд ТХГН-ийн орлого, зарлагын гүйлгээг хийж ирсэн байна.

1.2.3. 2016 оны 6 сараас 12 сар хүртэлх хугацаанд “Хамарын хийдийн цогцолбор газрын захиргаа” ОНӨААТҮГ-ын харилцах дансанд орлогыг бүрдүүлж, зарцуулсан бол 2017 оны 1 дүгээр сараас эхлэн Сайншанд сумын орлогын дансанд хураамжийн орлогыг төвлөрүүлж “Тохижилт Сайншанд” хот тохижилтын газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны зардлын төсвийг батлан санхүүжүүлсэн байна.

1.2.4. Хамрын хийд орчмын Цогцолборт газрын менежментийн төлөвлөгөөг 2015 онд боловсруулж аймгийн ИТХ, Засаг дарга баталсан байна. Тухайлбал: Цогцолборт газрын байгалийн нөөц, баялгийг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, санхүүгийн тотвортой эх үүсвэр бий болгох, цогцолборт газрыг хамгаалах хамтрагч талуудыг бий болгох, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, хянах мониторингийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлүүдээр хийгдэх ажлуудыг 2015-2019 оны байдлаар гаргажээ. Төсөв хөрөнгө, орон тоо, мэргэжлийн боловсон хүчин байхгүйгээс төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгээгүй байна.

1.2.5. Орчны бүсийн зөвлөл, хамгаалалтын захиргаа байгуулагдан ажиллаагүй, хураамжийн орлогыг Сайншанд сумын орлого бүрдүүлэх эх үүсвэр болгосноос Орчны бүсийн сангийн хөрөнгийг хуулиар тогтоосон нэр төрлүүдээс өөр зориулалтаар ашиглаж хяналтгүй зарцуулж ирсэн байна.

1.2.6. ТХГН-ийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагаа болон хөрөнгө санхүүг төлөвлөөгүй, нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих, байгаль орчныг нөхөн сэргээх, орчны доройтлыг бууруулах, орчны бүсэд судалгаа хийх ажлууд огт хийгдээгүй, мэдээлэл сурталчилгааны ажлууд хангалтгүй зохион байгуулагджээ. Тухайлбал: ТХГН-ийг хөгжүүлэх, хамгаалахад ургамлын аймгийн судалгаа, ховор, ховордож буй төрөл зүйлийн судалгаа, палентологи, түүх соёлын дурсгал, байгалийн баялаг, эрдэнэсийн нөөцийн судалгаанууд болон аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого шийдвэр шаардлагатай байгаа хэдий ч энэ талаар журмуудад тусгагдаагүй байна.

1.2.7. Сангийн үйл ажиллагаатай холбогдон гарсан журмууд нь орлогын эх үүсвэрийг бүрдүүлэхэд чиглэгдсэн бөгөөд ТХГН-ийн талаар гарсан хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах, сангийн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл тооцоо, хяналт, хариуцлагын асуудлыг тодорхой, нарийвчлан тусгаж өгөөгүй байна. Тухайлбал: Сумын Засаг даргын захирамжаар орон тооны бус зөвлөл байгуулж хөрөнгийг зарцуулах тусгай журам гаргаж мөрдөнө гэж заасан боловч журам гараагүй байна.

Бүлэг 2

Орлогын эх үүсвэр, зардлыг төлөвлөөгүйгээс сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

2.1. ТХГН-ийг хамгаалах ажлын төсөв, санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр болон үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлыг хуулийн дагуу төлөвлөж батлуулаагүй байна.

2.1.1. ТХГНТ хуулиар тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгө нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын болон бусад бусад ажил үйлчилгээний орлого, иргэн аж ахуйн нэгжийн хандив, тусламж, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого зэргээс бүрдэхээр заажээ. Мөн төсвийн тухай хуулиар орон нутгийн тусгай сан нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байхаар хуульчилсан.


2.1.2. Орчны бүсийн зөвлөл, хамгаалалтын захиргаа байгуулагдан ажиллаагүй, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтгүйгээс ТХГН-ийг хамгаалах ажлын төсөв, төлөвлөгөө гаргаж сангийн орлого, зарлагын төсвийг ИТХ-аар батлуулаагүй, менежментийн төлөвлөгөө гаргасан ч хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнээс шалтгаалж сангийн орлого олох эх үүсвэрийг тооцоогүй, орлого олох боломжийг алдсан, орлогын бүрдүүлэлтэд тавих шат шатны хяналт орхигдож, хууль журам зөрчсөн, зориулалт бус ажил үйлчилгээ, ТАХ-г санхүүжүүлж, сангийн хөрөнгийг хяналтгүйгээр үрэлгэн зарцуулсан байна.

2.2. ТХГН-т үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн хөлсийг батлагдсан үнэ тарифын дагуу хураасан боловч хураамжийн үнэ тариф өөрчлөгдсөн тухай бүрт тасалбарын үлдэгдлийн тооцоо хийгээгүй байна.

2.2.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн үйл ажиллагааг 2007-2016 оны эхний хагас жил хүртэл Сайншанд сумын ЗДТГ, 2016 оны сүүлийн хагас жилд “Хамарын хийдийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа” ОНӨААТҮГ, 2017 оноос “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газар тус тус эрхлэн явуулж иржээ.

2.2.2. ТХГН-т зорчих иргэд, тээврийн хэрэгслээс авах хураамжийн орлогыг 2013 онд ОНТХГНСанд, 2014-2016 онуудад байгаль хамгаалах санд, 2017 оноос Сайншанд сумын орон нутгийн орлогын дансанд тус тус төвлөрүүлж ирсэн байна. 2013-2016 онд иргэдээс авсан хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг *график №1-ээр харуулав.*

Тасалбарын орлого (сая.төг)



2017 оны 1-р улирлын байдлаар “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газар 27,119.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

2.2.3. ТХГН-т зорчих тээврийн хэрэгслээс 2015 онд 30,666.4 мянган төгрөг, 2016 онд 25,604.3 мянган төгрөг, 2017 оны 1-р улиралд 10,541.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

2.2.4. Хураамжийн үнэ тариф ИТХ-ын тогтоолоор өөрчлөгдсөн тухай бүр тасалбарын үлдэгдэл дээр тооцоо нийлж баримт үйлдээгүй байна. *Үнэ тарифын өөрчлөлтийг хүснэгт №1-д харуулав.*

Хүснэгт №1

Огноо	СИТХ-аар батлагдсан тариф төгрөгөөр		
	Монгол иргэн	Гадаад иргэн	Тээвэр
2011	500	2000	
2013			500
2013	1000		
2014	2000		
2015	2000		1000
2016	2000	5000	1000

ТХГН-т үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн хөлсийг батлагдсан үнэ тарифын дагуу хурааж орлогыг төвлөрүүлсэн байна. Харин төлбөрийн хэмжээнд өөрчлөлт орох үед батлагдсан үнэ тарифыг мөрдөж ажиллаагүй байна. Тасалбарын үнэ өөрчлөгдөхөд урьд нь мөрдөж байсан үнэтэй тасалбараа дуустал борлуулаад, дараа нь шинэчлэгдсэн тарифтай тасалбараа борлуулдаг байсан талаар тухайн үед ажиллаж байсан нярав, тасалбар борлуулагч нар тайлбарлаж байв.

2.2.5. ИТХ-аар батлагдсан үнэ тарифыг тухай бүр мөрдөөгүйгээс хураамжийн орлогын зарим хэсгийг нэмэгдсэн тарифын дагуу төвлөрүүлэх боломж алдсан байна.

2.3. Тасалбарын орлого, зарлагын 2013-2015 оны эд хариуцагчийн тайлан байхгүйгээс хураамжийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.

2.3.1. ТХГН-т зорчих иргэдээс авах хураамжийн тасалбарыг 2013-2016 онд Анулан ХХК, 2017 онд Соёмбо принтинг ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хэвлүүлсэн байна. Тээврийн хэрэгслээс авах хураамжийн тасалбарыг 2015-2017 онд сангийн үйл ажиллагааг эрхэлж байсан байгууллагууд өөрсдөө хэвлэж санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэж ирсэн байна.

2.3.2. Сайншанд сумын ЗДТГ нь 2013-2016 онд Анулан ХХК-иар нийт 368000 ширхэг тасалбар хэвлүүлэхээр 58,940.0 мянган төгрөг, 2017 онд “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газар 40000 ширхэг тасалбар хэвлүүлэхээр Соёмбо принтинг ХХК-д 5600.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

2.3.3. ТХГНС-ийн 2013-2015 оны тасалбарын орлого, зарлагатай холбоотой бараа материалын тайлан, анхан шатны баримтууд, борлуулсан тасалбарын үлдэх хэсгийг аудитын явцад ирүүлээгүй болно. Сайншанд сумын ЗДТГ-ын даргын 2017 оны 03/1374 тоот албан бичгээр 2013, 2014, 2015 онуудын бараа материалын тайлан болон борлуулсан тасалбарын үлдэх хэсэг Сайншанд сумын ЗДТГ-ын архивт байхгүй гэсэн тайлбар ирүүлсэн.

2.3.4. Тасалбарын орлого, зарлагатай холбоотой 2013-2015 оны бараа материалын тайлан, тасалбарын үлдэгдлийг тоолсон тооллогын бүртгэл байхгүйгээс аудитад хамрагдах хугацааны тасалбарын эхний үлдэгдэл тодорхойгүй, 2013-2016 онд Анулан ХХК-иар хэвлүүлсэн 368000 ширхэг тасалбар хүлээн авсан баримт байхгүй, тасалбар борлуулагч нарт өгсөн тасалбарын тоо хэмжээ тодорхойгүй, 74358 ширхэг борлуулсан тасалбарын үлдэх хэсэгт тооцоо нийлсэн баримт байхгүй байна.

2.3.5. 2013 онд Хутагтыг сэнтийд залах 4-р сарын 28-ны өдөрт зориулан 21700 ширхэг тасалбарыг тасалбар борлуулагч нарт олгосон байна. Тухайн өдрийн орлогыг нягтлан бодогч бэлнээр авсан тухай тасалбар борлуулагч нар тайлбар гаргаж байгаа хэдий ч кассад бэлэн мөнгө хүлээн авсан баримт, тайлан, тооцоо байхгүй байна. Тасалбарын орлого, зарлагатай холбоотой үнэт цаасны тайланг эд хариуцагч гаргаагүйгээс /2013-2015 оны баримт/ дансанд тушаасан орлогууд нь бүрэн орсныг нотлох боломжгүй байлаа.

2.4. Нягтлан бодогч, эд хариуцагч удаа дараа солигдон ажилласан, удирдлага зохион байгуулалт, хяналт орхигдсоноос хууль, журам зөрчиж сангийн хөрөнгийг зориулалт бусаар, үрэлгэн зарцуулсан байна.

2.4.1. ТХГН-ийн орчны бүсийн тухай хуулиар орчны бүсийн санг дор дурдсан арга хэмжээнд зарцуулна гэж заасан байна.

- Байгаль орчныг нөхөн сэргээх, орчны доройтлыг бууруулах,
- Нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд тусламж, дэмжлэг үзүүлэх, төсөл хэрэгжүүлэх,
- Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэрлэлийн техник, технологийг шинэчлэх,
- Байгаль орчныг хамгаалах, сургалт, сурталчилгаа явуулах, орчны бүсэд судалгаа хийх
- Байгалийн аюул гамшгаас учирсан хохирлыг арилгах.

2.4.2. ТХГН-ийн сангийн хөрөнгийг 2013-2016 онуудад сумын Засаг даргын захирамж, шийдвэрийн дагуу зарцуулж ирсэн бөгөөд 2013-2016 онд нийт 650.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Сангийн үйл ажиллагааны зарцуулалтыг 2013-2016 оны байдлаар хүснэгт №3-аар харуулав.

Хүснэгт №3		Сая төгрөгөөр			
	2013 он ОНТХГНС	2014 он БХС	2015 он БХС	2016 он БХС	2016 он ОНТХГНЗ
Цалин, урамшуулал	8.3	15.7	20.6	12.9	19.8
Татвар, шимтгэл	1.1	1.8	4.4	5.3	7.2
Цахилгааны зардал	0.1	0.2	1.7	1.9	0.8
Шатахууны зардал	0.1	0.3	2.3	2.2	0.6
Нэг удаагийн бусад зардал	15.1	9.9	46.1	33.1	11.9
Тасалбар хэвлүүлсэн, хогны уут, номны үнэ	4.5	6.6	28.8	30.0	
Хөрөнгийн зардал	7.6	35.0	59.3	40.6	18.3
Байгууллагуудад дэмжлэг	3.0	19.1	39.6	5.6	
Эргэн төлөгдөх нөхцлөөр олгосон мөнгө	-	31.9	22.1		
БХС-нд хаасан	12.9		19.4	8.8	
Орлого төвлөрүүлсэн					20.0
Үлдэгдэл төвлөрүүлсэн		8.2	4.9		0.6
ДҮН	52.7	128.7	249.2	140.4	79.2

2.4.3. ОНТХС-ийн хөрөнгөөр 2013-2016 онуудад нийт 160.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Тухайлбал: Хос хунгийн хөшөө усан оргилуур, хогийн сав, пункер, хайс, хашаа, хог зөөврийн авто машин, цэвэр, бохир ус зөөврийн сав, ус нөөцлөх сав, камер, компьютер, хилэнцийн хөшөө, агаарын чанарын харуулын байр, нийтийн бие засах газар, түүх соёлын газруудад товч тайлбар байрлуулжээ.

2.4.4. Тус сангаас сумын Засаг даргын захирамжаар эргэн төлөгдөх нөхцлөөр 54.0 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд 5.0 сая төгрөг эргэн төлөгдөж 49.0 сая төгрөгийн авлагатай байна. Үүнд:

1. 2014 оны 3 сарын 25-ны А/107 дугаар захирамжаар Эй Си Жи ХХК-д өмгөөллийн хөлс 1.0 сая төгрөг
2. 2014 оны 7 сарын 8-ны А/241 дүгээр захирамжаар ЕБ-ын I сургуулийн 90 жилийн түүхийн музей байгуулах 9.9 сая төгрөг
3. 2014 оны 7 сарын 31-ны А/256 дугаар захирамжаар Сайншанд сумын ЗДТГ-т иргэний танхим байгуулах 16.0 сая төгрөг
4. 2015 оны 7 сарын 10-ны А/208 дугаар захирамжаар Сайншанд сумын хүн амын ундны усны хангамжийг нэмэгдүүлэх, эрүүл ахуйг хангах зорилгоор 3-р багийн нутагт шинээр худаг гаргах, цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг амжилттай зохион байгуулсан Солонгос улсын иргэн Хичолд хүндэтгэл үзүүлэх 1.0 сая төгрөг
5. 2015 оны 7 сарын 17-ны А/209 тоот захирамжаар Ардын хувьсгалын 94 жилийн ой, Дорноговь аймаг байгуулагдсаны 54 жилийн ойн баяр наадмын соёл, урлаг, спортын арга хэмжээнд 8.0 сая төгрөг
6. 2015 оны 9 сарын 23-ны А/270 дугаар захирамжаар Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор Амарбаяраас өвс худалдаж авахад 13.1 сая төгрөг

Эдгээрээс Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуульд түүхийн музейг байгуулж хүлээн авсан комиссын акт үйлдсэн, Сайншанд сумын иргэний танхимыг байгуулж данс бүртгэлд тусгасан, өмгөөллийн хөлс, баяр наадмын зардлын баримтууд иж бүрэн байна.

Харин Солонгос улсын иргэн Хичолд дурсгалын зүйл авч өгсөн баримт байхгүй, иргэн Б.Амарбаяраас 2015 онд 13.1 сая төгрөгийн 2620 боодол өвс авч бараа материалын тайлан гаргахдаа бүх өвсийг зарлагадсан байна. Эд хариуцагчийн тайланд байгууллага, хүмүүст тараасан анхан шатны баримт байхгүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.1.1-д “НББ-ийн анхан шатны баримт холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” гэсэн заалт, СЭЗС, ҮСГ-ын даргын 2002 оны 171/111 тушаалаар баталсан өмчийн бүх хэлбэрийн ААНБ-д нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг хөтлөх зааварт “ААНБ-ын удирдлага, нягтлан бодогч нь хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтанд бичилт хийж бүрдүүлнэ ” гэсэн заалтыг зөрчиж байна.

2.4.5. Сумын Засаг даргын захирамжаар дараах байгууллагуудад 67.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлжээ.

1. Сайншанд сумын ЗДТГ-т 2013 оны 10 сарын 10-ны өдрийн А/322 тоот захирамжаар 2.5 сая төгрөгийн компьютер, хэрэгсэл,
2. Цагдаагийн газарт 2015 оны 07 сарын 17-ны А/215 дугаар захирамжаар Хамарын хийдийн цогцолбор газар нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах үйл ажиллагааны зардалд 3.0 сая төгрөг,
3. Хамрын хийд ТББ-т 2015 оны 8 сарын 19-ний А/233 тоот захирамжаар унд ахуйн зориулалттай худаг сэргээн засварлахад 3.7 сая төгрөг,
4. “Тохижилт Сайншанд” хот тохижилтын газарт 2016 оны 6 сарын 30-ны А/204 тоот захирамжаар ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээхэд 5.6 сая төгрөг тус тус олгосон байна.

2.4.6. Нэг удаагийн бусад зардлуудад нийт 125.1 сая төгрөг зарцуулсан бөгөөд 62.1 сая төгрөгийн зориулалт бус зардал гаргасан байна. Үүнд:

1. Баяр наадмын бэлтгэл ажилд 2.5 сая төгрөг Засаг даргын захирамж 2013 оны 5, 6 дугаар сарын А/170, А/206
2. Сайншанд сумын ЗДТГ-ын ХБТасагт компьютер 2.5 сая төгрөг Засаг даргын захирамж 2013 оны 10 сарын 10-ны А/322
3. Өвөлжилтийн бэлтгэл хангаж хивэг худалдаж авахад 3.75 сая төгрөг Засаг даргын захирамж 2015 оны 10 сарын 13-ны А/292
4. Явган хүний гарцын тэмдэг тэмдэглэгээ хийх 5.7 сая төгрөг Засаг даргын захирамж 2015 оны 10 сарын 8-ны А/279
5. Авто тээвэрчдийн дурсгалын самбар, Сайншанд сумын анхны байшингийн суурь дурсгалын хөшөө суурилуулахад 2.9 сая төгрөг Засаг даргын захирамж 2015 оны 10 сарын 2-ны А/279
6. Урлаг соёлын арга хэмжээнд 2.0 сая төгрөг Засаг даргын захирамж 2015 оны 8 сарын 19-ний А/233
7. Засаг даргын захирамжгүй, Шинэ тэмдэг ХХК-тай 2015 оны 7 сарын 2-нд хэвлэлийн эх бэлтгэх, зургийн цомог гаргах 15.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан, 2015 оны 7, 12 дугаар сард нийт 6.0 сая төгрөг шилжүүлсэн
8. Баялаг бүтээгчдийн зөвлөгөөн 8.3 сая төгрөг Засаг даргын захирамж 2015 оны 10 сарын 29-ний А/325
9. Автобусны буудлыг шинэчлэн будах 0.7 сая төгрөг Засаг даргын захирамж 2016 оны 5 сарын 10-ны А/116
10. Эрүүл мэндийн үйлчилгээ, архигүй Сайншанд арга хэмжээ 2.0 сая төгрөг Засаг даргын захирамж 2016 оны 5 сарын 12-ны А/106
11. Баяр наадмын сурын харвааны бай шагналд 4.0 сая төгрөг Засаг даргын захирамж 2016 оны 7 сарын 25-ны А/226

2.4.7. Тасалбар түгээгч нарт 2013-2016 онуудад нийт 77.3 сая төгрөгийн урамшуулал олгосон бөгөөд урамшууллыг хэдэн хувиар тооцож олгох шийдвэр байхгүй байна. Урамшууллыг 2013-2014 онд орлогын 15 хувиар, 2015-2016 онуудад орлогын 7 хувиар тус тус тооцсон байв.

2.4.8. Урамшууллын тооцооллыг харилцахад тушаасан орлогын дүнтэй тулгахад 2013 онд 1.8 сая төгрөгийн орлогыг илүү тооцож 270.0 мянган төгрөг, 2014 онд 760.0 мянган төгрөгийн орлогыг илүү тооцож 114.0 мянган төгрөг, 2015 онд 4.2 сая төгрөгийн орлогыг илүү тооцож 294.0 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон зөрчил илэрсэн бөгөөд мөнгө хураагч нар уг зөрчилд тайлбар гаргахдаа тасалбарын орлогыг зарим тохиолдолд бэлнээр тушаасан гэх боловч бэлэн мөнгө тушаасан орлогын баримт материал байхгүй байлаа. Тухайлбал: Солонгочимэг 2015 оны 8 сард 4.2 сая төгрөг бэлнээр тушааж урамшуулал тооцох орлогын дүнд оруулсан тухай гар тэмдэглэлээ үзүүлсэн боловч кассад хүлээн авсан орлого, бэлэн мөнгөний тайлан байхгүй, хэн хүлээн авсныг нотлох боломжгүй байна.

2.4.9. ОНТХГНС-ийн үйл ажиллагааг хариуцаж байсан нягтлан бодогч, эд хариуцагч удаа дараа солигдсон, удирдлага зохион байгуулалт, хяналт орхигдсоноос хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж, сангийн хөрөнгийг зориулалт бусаар, үрэлгэн зарцуулсан, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ явуулсан, анхан шатны баримтыг архивын нэгж болгож хадгалах ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Сумын Засаг даргын 2015 оны 6 сарын 22-ны А/178 дугаар захирамжаар түүх соёлын чиглэлээр мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх, түүхийн өв соёлыг сурталчлах зорилгоор 5.4 сая төгрөгийг ТХГНС-аас гарган зарцуулах шийдвэр гарсны дагуу 2015 оны 6 сарын 24-нд иргэн Н.Жавхлантөгстэй 3.5 сая төгрөгийн ажил гүйцэтгэх хүчин төгөлдөр бус гэрээ байгуулж 3.15 сая төгрөг шилжүүлсэн бөгөөд /татварт 350.0 мянган төгрөг шилжүүлсэн/ ямар ажил гүйцэтгэсэн нь тодорхой бус байна. 2015 оны 7 сарын 17-нд Н.Нарантуяад 500.0 мянган төгрөг шилжүүлсэн бөгөөд /нэхэмжлэх дээр төмрийн үнэ / материалын тайлан, холбогдох анхан шатны баримт байхгүй байна.
- Зарим гүйлгээний баримтуудыг Сайншанд сумын ЗДТГ-ын болон эрсдэлийн сангийн баримтад үдсэн байв.
- Анулан ХХК-д 2016 онд “Хөгжлийн төв-Сайншанд” тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн тайлан /ном/ хэвлүүлэхээр 10.0 сая төгрөг шилжүүлсэн боловч эд хариуцагч уг номыг данс бүртгэлд хүлээн авч зарлагадсан баримт байхгүй байна.

2.5 Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ажлуудад ХАА-г зохион байгуулаагүй, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлаагүй байна.

2.5.1. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн дараах хөрөнгө оруулалтын ажлуудыг гүйцэтгэхдээ ТБОНӨХБАҮХАТ хуулийн тендер шалгаруулалтын онцгой журмыг зөрчиж, харьцуулалтын аргыг хэрэгжүүлээгүй, худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй хариуцлагатай байх зарчмыг баримтлаагүй байна. Үүнд:

- Засаг даргын захирамжаар ОНТХГН-т зорчигч иргэдээс нэг удаагийн төлбөр авахад олгох тасалбарыг 2013-2016 онуудад Анулан ХХК-иар гүйцэтгүүлж ирсэн ба жилд 4.5-27.7 хүртэл сая төгрөг шилжүүлж тасалбар хийлгэжээ. Тус онуудад Анулан ХХК-д шилжүүлсэн мөнгө, тасалбарын тоо хэмжээг хүснэгт №2-оор харуулав.

Хүснэгт №4		мянган төгрөг
Он	Тоо ширхэг	Мөнгөн дүн
2013	82000	4540.0
2014	95000	6650.0
2015	111000	27750.0
2016	80000	20000.0
Дүн	368000	58940.0

Анулан ХХК-д тасалбараас гадна 2015 онд 10000 ширхэг хогны уутны үнэ 1.0 сая төгрөг, 2016 онд номны үнэ 10.0 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

- Засаг даргын 2015 оны 3 сарын 31-ний өдрийн А/81, 2016 оны 3 сарын 28-ны өдрийн А/88 дугаар захирамжуудыг үндэслэн Монгол төгс баримал ХХК-тай Хилэнцийн хөшөөний ажлын 3D зургийг 9.8 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр, уг хөшөөний эх моделийг 10.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна. Засаг даргын 2016 оны 3 сарын 28-ны А/87 дугаар захирамжийн дагуу иргэн Б.Мөнхтөртэй хилэнцийн хөшөөг металл дээр буулгаж суурилуулах ажлыг 10.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгосон байна. Хилэнцийн хөшөөний ажлыг 2016 оны 5 сард Захирагчийн ажлын албаны дарга, ЗАА-ны мэргэжилтэн, Төхижилт Сайншанд хот төхижилтын менежер, Сайншанд хотын архитектор нар хүлээн авч акт үйлдсэн байна.



Зураг №1 Хилэнцийн хөшөө

Тус хилэнцийн хөшөөг зураг төсөлд заасан хэмжээ, дизайн, өнгө, дүрслэлийн дагуу шаардлага бүрэн хангасан материалаар түүний суурьт бэхлэн заагдсан хэмжээгээр байршуулна гэж гэрээнд заасан боловч суурилуулаагүй, “Төхижилт Сайншанд” хот төхижилтын газрын хашаанд хадгалж байна. Үүнд хөшөөг суурилуулж хүлээн авах тухай албан шаардлага бичлээ.

- Хүрэл унага ХХК-иар хос хунгийн хөшөөг 9250.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэх гэрээг 2014 онд байгуулсан бөгөөд 7 сарын 13-нд ашиглалтанд хүлээлгэн өгөх хугацаатай байсан боловч 9 сарын 10-нд хүлээн авсан байна. Хос хунгийн нэгнийх нь хошуу хугарсан, нэгнийх нь толгой салж унасан байдалтай байна.

- Хамарын хийдэд 2016 онд усан оргилуур хийх ажлыг Сайншанд өргөө ХХК-иар гүйцэтгүүлэхээр 9.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд гэрээний хугацааг 2 сараар хэтрүүлсэн байна. Усан оргилуурыг комисс хүлээн авсан акт үйлдсэн боловч ажиллаагүй, элс шороонд дарагдсан байна. Иймд усан оргилуурыг ашиглалтад оруулах, хунг сэргээн засварлуулахаар албан шаардлага бичлээ.



Зураг №2 хос хунгийн хөшөө, усан оргилуур

- Дэнж наяд ХХК-иар 2014 онд Хамарын хийдийн түүх дурсгалт газруудад байршуулах тайлбарыг Олон улсын жишигт нийцүүлэн гүйцэтгүүлэхээр 7.0 сая төгрөгийн гэрээ, иргэн А.Батцэцэгтэй тайлбар хийх байгалийн саарал боржин чулуу 23 ширхэгийг худалдан авах гэрээ тус тус байгуулсан байна. Түүх соёлын дурсгалт газрын товч тайлбар бичсэн боржин чулуун дээрх тайлбар үг арилж, гялгар төмөр болон үлдсэн байна.



Зураг №3 Том чулуун дээрх тайлбар




Зураг №4 жижиг чулуун дээрх тайлбар

Дэнж наяд ХХК-иар тайлбарыг дахин хийлгүүлж авах албан шаардлага бичлээ.

2.5.2. ТХГНС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал: Хамарын хийд дэх Адаг худгийн хамгаалалтын хашааны зарим хэсэг алга болсон, бохир соруулах насос эвдэрсэн, нийтийн бие засах газрыг ажиллуулаагүй байна.



Зураг № 5 Адаг худгийн хашаа



Зураг №6 Бохир соруулах насос



Зураг №7 Бие засах газар

Өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор 2015 онд иргэн Ц.Шүрэнцэцэгээс 3.75 сая төгрөгийн 300 ширхэг хивэг худалдан авсан бөгөөд худалдан борлуулаагүй, Сайншанд сумын ЗДТГ-ын агуулахад өнөөг хүртэл хадгалагдаж бороонд норж хөгцөрсөн, чанар байдлаа алдсан байна. Эд хариуцагч бараа материалын тайлан гаргахдаа хивгийг зарлагадаж үлдэгдэлгүйгээр тайлагнасан бөгөөд нягтлан бодогч түүнийг хянаж гарын үсэг зурж, санхүүгийн тэмдэг дарсан байна.



Зураг №8 хивэг



Зураг №9 хивэг

2.5.3. Засаг даргын захирамжинд ажил гүйцэтгэгч иргэн, байгууллагатай гэрээ байгуулж ажиллах тухай тусгасан байхад зарим ажлуудад гэрээ байгуулаагүй, гүйцэтгэсэн ажлаа тайлагнаагүй, гэрээ байгуулсан ч ажлыг хүлээн авсан акт байхгүй, гэрээний хугацааг хэтрүүлсэн, хэтэрсэн хоногт алданги тооцоогүй байна. Тухайлбал:

Гэрээ байгуулаагүй, ажлын тайлан, хүлээн авсан актгүй:

- Б.Гантулгаар явган хүний гарцын тэмдэг тэмдэглэгээ хийхэд 5.7 сая төгрөг 2015 он, Н.Жавхлантөгс 3150.0 мянган төгрөг 2015 он хүчин төгөлдөр бус гэрээ байгуулсан, ямар ажил хийх нь тодорхойгүй,
- Хамрын хийд ТББ 2.0 сая төгрөг урлаг соёлын арга хэмжээ гэсэн нэхэмжлэхтэй, 2015 он, хамрын хийд орчмыг сэргээн засварлах 20.0 сая төгрөг, зарцуулалтын тайлан ирүүлээгүй 2015 он
- “Сайншанд Тохижилт” хот тохижилтын газар ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх 5.6 сая төгрөг зарцуулалтын тайлан ирүүлээгүй 2016 он,
- Иргэн М.Мөнх-Эрдэнэ камер суурилуулах ажилд 7.3 сая төгрөг, ажил хүлээн авсан актгүй 2015 он
- Иргэн Ц.Төрмөнх хогийн сав хийх ажилд ОНХС-ийн хөрөнгөөр 2.9 сая төгрөг, ТХГНС-ийн хөрөнгөөр 2.1 сая төгрөг нийт 5.0 сая төгрөг ажил хүлээн авсан актгүй 2016 он

2.5.4 ОНТХГНС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгүүдээс “Тохижилт Сайншанд” хот тохижилтын газарт 9250.0 мянган төгрөгийн хос хун, 44.8 сая төгрөгийн хог зөөврийн авто машин, хамгаалалтын захиргааны бүртгэлд 6 нэр төрлийн 15.2 сая төгрөгийн хөрөнгө тус тус бүртгэлтэй байна. Харин 14 нэрийн 95.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна. Хөрөнгийг данс бүртгэлд тусгуулахаар албан шаардлага бичлээ.

Бүлэг 3

Холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүйгээс орон нутгийн ТХГНС-ийн үйл ажиллагаанд тавих хяналт орхигдсон байна.

3.1 Мөнгөн кассын журмын заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

3.1.1. Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.13-д "...ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбарын өөрт үлдэх хувь) тооцооог гаргаж, тайлан тушаана" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

ОНТХГН-т ажиллаж байсан тасалбар борлуулагч нар тасалбарын орлогыг гар дээрээ олон хоног хуримтлуулж тушаасан байв. Тухайлбал: 2013 онд 15-30 хоног, 2014 онд 10-40 хоног, 2015 онд 10-35 хоног, 2016 онд 7-10 хоног гар дээр хуримтлуулж байгаад дансанд төвлөрүүлсэн байна.

2017 онд Тохижилт-Сайншанд хот тохижилтын газар нь хамарын хийдийн постын орлогыг гар дээр 7 хоног, автозамын постны орлогыг нярав касст 7 хоног байлгаж байгаад орлогын дансанд төвлөрүүлдэг байна. Тасалбарын орлогыг өдөр бүр тушаах боломж байдаггүй талаар Тохижилт-Сайншанд хот тохижилтын газар дараах тайлбарыг ирүүлсэн.

- Хамарын хийдийн постонд ажиллаж буй тасалбар түгээгч бүтэн 7 хоногоор ээлжинд гардаг,
- Хамарын хийдийн пост нь аймгийн төвөөс 40 км-т байрладаг,
- Орлого өдөр бүр тушаах шатахууны зардал байдаггүй
- Ээлжинд гарсан түгээгч нар ажлын байранд бэлтгэж өгсөн сайфэнд орлогоо хадгалж байгаад 7 хоног бүрийн даваа гарагт дансанд тушаадаг
- Автозамын постны орлогыг тушаах бүрт гүйлгээний шимтгэл нь 500 төгрөг байдаг учраас касст хуримтлуулж байгаад 7 хоногт 1 удаа төвлөрүүлдэг.

3.1.2. Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6-д "Төсвийн байгууллага.....орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг (түүнийг шууд зарцуулах эрхгүй) ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна. Тухайлбал: 2013 оны 4-р сарын 28-ны өдөр Хутагтыг сэнтийд залах ёслолд зориулан бэлтгэсэн 21700 ширхэг тасалбарыг тасалбар борлуулагч нарт шаардах хуудас бичиж олгосон бөгөөд 10.0 сая гаруй төгрөгийн орлогыг холбогдох дансанд тушаасан баримт байхгүй байна.

3.1.3. Хамарын хийд болон автозамын постын үйл ажиллагаатай танилцаж тасалбар, бэлэн мөнгөний тооллого явуулсан. Хамарын хийдийн постын тасалбараас нийт 46.0 мянган төгрөгийн 23ш тасалбар дутагдсан байсныг аудитын явцад барагдуулж орлогыг дансанд төвлөрүүлсэн болно.

3.2. Сангийн хөрөнгийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад тавих шат шатны хяналт орхигдсон байна.

3.2.1 Сайншанд сумын ИТХ-ын тогтоолуудаар ТХГНС-гийн орлого, зарцуулалтад СИТХ, түүний тэргүүлэгч хяналт тавьж ажиллахаар заасан боловч хэрэгжүүлээгүй байна.

3.2.2. Сумын ИТХ-ын 2014 оны 08/04-р тогтоолоор Хамарын хийдэд үйл ажиллагаа эрхэлж байгаа ААНБ, иргэдээс хураамж авахаар шийдвэрлэсэн байна.

- Гэр буудал сар бүр-20000 төгрөг,
- Нийтийн хоолны үйлчилгээ сар бүр-20000 төгрөг,
- Жижиглэн худалдаа бэлэг дурсгал-сар бүр 15000 төгрөг,
- Үсчин дугуй засвар гэх мэт бусад үйлчилгээ-сар бүр 10000 төгрөг,
- Түр отоглох өөрийн орон сууц бүхий аялагчид жуулчдаас-майхан, сууц бүрээс-тухай бүр 5000 төгрөг

Хамарын хийдэд үйл ажиллагаа явуулж буй ААНБ-аас сангийн орлого бүрдүүлэх ажлыг сумын ЗДТГ-аас зохион байгуулаагүй байна. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 15 иргэний 75 гэр буудал, худалдаа бэлэг дурсгал бүхий 1-2 дэлгүүр, 5-10 түр отоглох майхан сууц зэргээс 10.0 сая гаруй төгрөгийн хураамжийн төлбөр 2014-2015 онд аваагүй байна. Сумын ИТХ-ын 2015 оны 11/03 тогтоолоор дээрх тогтоолыг хүчингүй болгосон байна.

3.2.3. Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн 2014-2015 он, 2016 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд шалгалт хийж ОНТХГНС-ийн хөрөнгийн зарцуулалтын журам боловсруулаагүй, хөрөнгийн зарцуулалт хяналт тавьж ажиллаагүй талаар дүгнэлт бичсэн байна.

3.3. Орон нутгийн тусгай хамгаалалтын горим тогтоож, хяналт тавьж ажиллаагүй байна.

3.3.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28.3-д ИТХ-нь нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, түүний хилийн зааг, хамгаалалтын горимыг тогтоох бүрэн эрхтэй гэж заасан байна. Сумын ИТХ-ын 1998 оны 6/8 тогтоолоор баталсан Хамарын хийд орчмын хамгаалалтын горимыг СИТХ-ын 2010 оны 5/04 тогтоолоор хүчингүй болгожээ. ТХГН-ийн хилийн зааг, газрын хэмжээнд өөрчлөлт оруулсан боловч хамгаалалтын горим тогтоосон шийдвэр дахин гараагүй байна.

3.3.2 Аймгийн БОАЖГ, Сумын ЗДТГ-ын тухайн үед ажиллаж байсан холбогдох албан тушаалтанууд хууль журмын дагуу дурсгалт газрын ашиглалт, хамгаалалтын горим тогтоох талаар асуудал боловсруулж шийдвэрлүүлээгүй, ажлын уялдаа холбоо хангалтгүй зэргээс шалтгаалж өнөөг хүртэл горим тогтоож, хяналт тавьж ажиллаагүй байна.

3.3.3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 42.1-д “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина” гэж заасан байна. Сумын Засаг даргын 2013 оны А/46 захирамжаар Хамарын хийдийн орчимд худалдаа үйлчилгээ эрхлэн үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний газруудад хяналт шалгалт хийх ажлын хэсэг, 2013 оны А/329 захирамжаар ТХГН болох Хамарын хийдийн ойр орчимд худалдаа үйлчилгээ эрхлэн явуулж байгаа үйлчилгээний газруудад хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулахаар тус тус шийдвэрлэсэн боловч хяналт шалгалт хийсэн ажлын тайлан байхгүй байна.

3.3.4. Иймд холбогдох хуулийн дагуу хамгаалалтын горим тогтоож, дурсгалт газарт хаалт хашлага барих, сайжруулах, сэрэмжлүүлсэн дохио тэмдэг тавих, түүний хамгаалалтыг нутгийн оршин суугчдад хариуцуулан өгөх зэрэг хамгаалалтын арга хэмжээ авах шаардлагатай байна.

3.3.5 Байгаль орчны хяналтын улсын байцаагч иргэд, олон нийтээс ирүүлсэн мэдээллийн дагуу хууль бусаар алт ухах, ан хийж буй байдалд шалгалт хийж хууль, зөрчигчдөд эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага тооцон ажилладаг байна. Тухайлбал: Ханбаян зүрх ууланд алт ухаж байна гэсэн мэдээллийн дагуу аймгийн Цагдаагийн газартай хамтран ажиллаж металл хайгчийг хураан авсан. Хамарын хийдээс элс ачиж байна гэсэн мэдээллийн дагуу очиж зөрчлийг арилгуулсан байна.

ТХГН-т ажиллаж буй идэвхтэн байгаль хамгаалагч нар жил бүр өөрт ногдсон талбайд чиг үүргийнхээ дагуу эргүүл хийж тайлан мэдээг Сумын ЗДТГ-т хүргүүлсэн байв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн зөвлөл байгуулж ажиллаагүйгээс менежментийн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлээгүй, үйл ажиллагаа нь удирдлага, зохион байгуулалтгүй, сангийн хөрөнгийн орлогын эх үүсвэр, хуваарилалт, зарцуулалтад тавих хяналт орхигдсон байна.

ТХГН-ийн хамгаалалтын захиргааны бүтэц зохион байгуулалт оновчгүй, хуулиар заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг хүрэлцээтэй хуваарилаагүй, цогцолборт газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хариуцсан ажилтан дүрэмт хувцас, ялгах тэмдэг, зэвсэг хэрэгсэлгүйгээс хууль, журам, хамгаалалтын горимыг тайлбарлан таниулах, зөрчлийг таслан зогоох бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй байна.

ТХГН-ийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн хөрөнгийн эх үүсвэр, зарлага, санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөж, ИТХ-аар батлуулаагүй, удирдлага, зохион байгуулалт, хяналт орхигдсоноос сангийн хөрөнгийг зориулалт бусаар, үрэлгэн зарцуулсан байна.

Хутагтыг сэнтийд залах ёслолд зориулан бэлтгэсэн 21700 ширхэг тасалбарын зарцуулалт, мөнгөн орлогын баримт, тасалбар түгээгчийн кассад бэлнээр тушаасан 4.2 сая төгрөгийн орлогын баримт, бэлэн мөнгөний тайлан байхгүй байна.

Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ажлуудад ХАА-г зохион байгуулаагүй, шаардлагагүй, үр ашиггүй ажлуудыг санхүүжүүлсэн, хийгдсэн ажлууд чанаргүй, төсвийн хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлаагүй байна.

Эд хариуцагч тайлан тооцоогоо цаг хугацаанд нь үнэн зөв гаргаагүй, хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй, нягтлан бодогч хуулиар хүлээсэн эрх үүргээ биелүүлж ажиллаагүй байна.

Холбогдох хуулийн дагуу дурсгалт газрын ашиглалт, хамгаалалтын горим тогтоож, хяналт тавьж ажиллаагүй байна.

Аудитаар нийт 484.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж хөрөнгө бүртгүүлэх 95.8 сая төгрөгийн 1, ажил дуусгуулах 3, нийт 4 албан шаардлага бичиж, нотлох баримтгүй бэлэн мөнгөний асуудлыг хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шийдвэрлэж, 388.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин танаа:

1. Хамгаалалтын захиргааг мэргэжлийн ажиллагсадтай, бие даасан үйл ажиллагаанд шилжүүлэх асуудлыг зохион байгуулах
2. ОНТХГН-ийн тухай хуулиар заасан тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горимын биелэлтийг хангуулах, ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, газар нутгийн ач хобогдол, хуулийг сурталчлах гэсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Сайншанд сумын ИТХ-ын дарга Д.Эрдэнэбаяр танаа:

1. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих
2. Сумын Засаг даргын орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжүүлсэн ажлын тайланг хэлэлцэж, зохих шийдвэр гаргаж биелэлтийг хангуулж ажиллах

Сайншанд сумын Засаг дарга С.Одбаяр танаа:

1. Түүх дурсгал, байгалийн баялаг, аялал жуулчлал хөгжүүлэх таатай нөхцөл, боломжийг үр дүнтэй, үр өгөөжтэй ашиглах, хөгжүүлэх бодлого шийдвэр гаргах
2. Хамгаалалтын захиргааны хөрөнгө, санхүү, бүртгэл тайлагнал, орлого бүрдүүлэлт, хөрөнгө оруулалт, зардалд шат шатны хяналтыг хэрэгжүүлэх
3. Цогцолборт газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах
4. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгуулах
5. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжсэн ТАХ-ний ашиглалтыг сайжруулах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч. АРИУНАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,

Утас/факс: (705) 2-25-33

E-mail: domogobi_mgl@yahoo.com

2014.08.01 № 1/401
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА ТАНАА

Аймгийн ИТХ-ын захиалгаар хийгдсэн “Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн 2013-2016 оны үйл ажиллагаа, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн зөвлөл байгуулах, менежментийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, мэргэжлийн ажиллагсадтай, бие даасан үйл ажиллагаанд шилжүүлэх асуудлыг хуулийн хүрээнд судлан шийдвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулах болно.


ТЭНХТҮВШИН

02 1363



**ДОРНОГОВЬ АЙМАГ
САЙНШАНД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,

Утас: (705) 2-31-48

2017.07.27

№

103

танай

-ны №

-т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн 2013-2016 оны үйл ажиллагаа, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн тайланд өгөх саналаа хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай

ДАРГА

Д. ЭРДЭНЭБАЯР

М. Лундман
2017.07.31

Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн
103 дугаар албан бичгийн хавсралт

Тайланд өгөх санал

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол тухайн оны эхнээс мөрдөгдөж эхэлдэггүй бөгөөд тогтоол гарсан хугацаа ба тогтоолд заасан хугацаанаас эхлэн мөрдөгдөх тул зарцуулалтыг он сар өдөртэй нь харуулах шаардалагатай байна
2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын батлагдсан журмын хүрээнд гаргасан үйл ажиллагааны зардал хөрөнгийн зориулалт ямар журмаар нотлогдож байгаа болон хууль бус шийдвэрүүдийг тодорхой болгох
3. Мөрдөх ажлаар: Тогтоол шийдвэрийн алдагдлыг нөхөн төлүүлэх, өглөгөд харуулах жишээ нь: Хамарын хийд орчмын гэр буудал, үйлчилгээ сарын хураамж 2014.08.06 08/04 тогтоолын хэрэгжилт



**ДОРНОГОВЬ АЙМАГ
САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГА**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,

Утас/факс: (705) 2-24-40

2017.07.31 № 01/1506
танай 2017.07.25 -ны № 1-6/516 -т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА ТАНАА**

“Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сангийн 2013-2016 оны үйл ажиллагаа, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

Тайлант тухайн цаг хугацаанд ажиллаж байсан холбогдох албан тушаалтнуудад хуулийн дагуу хариуцлага ногдуулахаар хууль сахиулах байгууллагад шилжүүлэх тухай саналыг хүргүүлж байна.



С.ОДБАЯР

052440

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Сумын ИТХ-аас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

1. Аудитын дүнгийн 2.4 дэх хэсэгт сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж шийдвэрийн огноо, дугаар болон зөрчил бүхий ажил гүйлгээний баримтуудын утгыг дэлгэрүүлж бичиж орууллаа.
2. Аудитын тайланд зөрчигдсөн хуулиуд болох ОНТХГНТ хууль, ОНТХГН-ийн орчны бүсийн тухай хууль, ХАА болон НББ-ийн хуулиудын заалтыг бичиж дор бүр нь зөрчлүүдийг бичсэн болно.
3. Сумын ИТХ-ын 2014 оны 08/04 тоот тогтоолоор баталсан “Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт дагаж мөрдөх журам” хэрэгжиж байх хугацааны төлбөрийг нөхөн төлүүлэхээр холбогдох иргэдтэй уулзахад тухайн үед энэ журмыг танилцуулж байгаагүй, хүчингүй болсон тогтоол, журмаар төлбөр төлөхгүй гэсэн тайлбар ирүүлээд байна.

Сумын Засаг даргаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

1. Анхан шатны нотлох баримтгүй, хариуцах эзэн тодорхойгүй, өмч хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах саналыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Ахлах аудитор

Ц.Лүндэгмаа

Шинжээч

П.Энхбаяр

ХЯНАСАН:

Аудитын менежер

Ч.Хэрлэнчимэг

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.